



ХААН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

(СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3.10-т
заасны дагуу)

Улаанбаатар хот
2026.04.24

АГУУЛГА

- 1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
- 2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
- 3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал
- 4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
- 5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр, дэг
- 6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүд
- 7 Саналын хуудасны загвар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

ХААН БАНК ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“ХААН Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

Хурал болох газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж-25, ХААН Банкны Сөүл оффисын 1-р давхар, ХААН театр

Хурал болох өдөр, цаг: 2026 оны 04-р сарын 24-ний өдрийн 14:00 цаг

(Танхимаар оролцох хувьцаа эзэмшигч хурал эхлэхээс нэг цагийн өмнө ирж бүртгэл хийлгэнэ)

Хурлын хэлбэр: Хосолсон (танхим болон цахим)

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04-р сарын 02-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Танилцуулах асуудал:

- 1.1 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- 1.2 “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан;
- 1.3 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан;
- 1.4 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт;
- 1.5 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
- 1.6 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга;
- 1.7 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.

2. Хэлэлцэн батлуулах асуудал:

- 2.1 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
- 2.2 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв;
- 2.3 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
2. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
3. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт;
4. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
5. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга;
6. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудас;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
9. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигч та 2026 оны 04-р сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд дараах газруудын аль нэгэнд хандан, эсхүл ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхаг;
- Хурал зохион байгуулах комисс (утас 75153333-3221; цахим шуудан investor_relations@khanbank.com).

Хуралд танхим болон цахимаар оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан, эсхүл Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхагт хүргүүлэх, мөн цахим хэлбэрээр ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан өгөх боломжтой. Саналын хуудсыг авах эцсийн хугацаа 2026 оны 04-р сарын 21-ний өдрийн 16:00 цаг байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 13-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын холбогдох зохицуулалтуудад заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.2 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасныг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

1. **ТОГТООХ НЬ:** Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цаг (Улаанбаатар хотын цагаар)-т Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж-25, ХААН Банкны Сөүл оффист байрлах ХААН Театрт хосолсон (танхим болон цахим) хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. **ТОГТООХ НЬ:** Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Т.Дарьбум/-д энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг даргалахыг даалгасугай.
3. **ТОГТООХ НЬ:** Банкны Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-г Хурал зохион байгуулах комиссын даргаар томилсугай.
4. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.
5. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн бирж, Банкны цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс /Р.Мөнхтуяа/-г үүрэг болгосугай.
6. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.



7. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
8. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
9. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт №2-ын дагуу баталсугай.
10. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын Хавсралт №3-ын дагуу байгуулсугай.
11. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
12. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхим болон зайнаас буюу цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл технологийн цахим шийдлийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Р.Мөнхтуяа/-т даалгасугай.
13. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 16:00 цаг хүртэлх хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Монгол Улс, Улаанбаатар хот, 15 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк Цамхагт хүргүүлэх, эсхүл цахим хэлбэр /www.khanbank.com/-ээр авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст /Р.Мөнхтуяа/-т даалгасугай.
14. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын дарга /Б.Онон/-д үүрэг болгосугай.
15. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

БАТЛАВ



Гүлэв овогтой Дарьбум

Дашдаваа овогтой Хулан

Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан



Кисабуро Иший

Жон Но

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонгегяанс

Батболд овогтой Амарсанаа



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Танилцуулах асуудал:

- “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан;
- “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан;
- “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт;
- “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
- “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга;
- “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.

2. Хэлэлцэн батлуулах асуудал:

- “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
- “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв;
- “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ХААН БАНК**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
2. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
3. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт;
4. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
5. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга;
6. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудас;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
9. Компанийн тухай хуулийн 65.6 дахь хэсэгт заасан шаардлагатай бусад баримт бичиг.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Харилцагч хариуцсан захирал Б.Онон

Комиссын гишүүд:

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал С.Дөлгөөн

“ХаанЛекс Партнерс” ХХН-ийн Гүйцэтгэх захирал, партнер И.Учралбаяр

“ХаанЛекс Партнерс” ХХН-ийн Ахлах хуульч О.Намуун

Комиссын нарийн бичиг:

ТУЗ-ийн Ажлын албаны хуулийн мэргэжилтэн Ж.Үүрцайх



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛАВАХ
ХУУДАС №1**

Компанийн нэр: “ХААН Банк” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
 Хувьцаа эзэмшигчийн регистрийн
 дугаар: _____
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн
 Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт (УБ хотын цагаар) биечилсэн болон цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	“ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах эсэх	☐	☐	☐
2.	“ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах эсэх	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн/Үнэт цаасны компани: _____ / _____

Саналын хуудсыг хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2026 оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. Та саналаа урьдчилсан байдлаар заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк Цамхагт хүргүүлэх, мөн цахим хэлбэрээр ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан өгөх боломжтой.
3. Хэрвээ өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, залруулгатай, тэмдэглэгээ буруу үйлдсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
5. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.
6. Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ
ХУУДАС №2**

Компанийн нэр: “ХААН Банк” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
 Хувьцаа эзэмшигчийн регистрийн
 дугаар: _____
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн _____
 Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт (УБ хотын цагаар) биечилсэн болон цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1.		
2.		
3.		
4.		
5.		
6.		
Хараат бус гишүүн		
1.		
2.		
3.		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн/Үнэт цаасны компани: _____ / _____

Саналын хуудсыг хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2026 оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Ердийн гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, хараат бус гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
 - а. Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно. Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.
3. Та саналаа урьдчилсан байдлаар заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк Цамхагт хүргүүлэх, мөн цахим хэлбэрээр ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан өгөх боломжтой.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд Таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, зарлуулгатай, тэмдэглэгээ буруу үйлдсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.
7. Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Танилцуулах асуудал:

- 1.1 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
- 1.2 “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан
- 1.3 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан
- 1.4 “ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт
- 1.5 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга
- 1.6 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга
- 1.7 “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга

2. Хэлэлцэн батлуулах асуудал:

- 2.1. “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
- 2.2. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв
- 2.3. “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Харилцагч хариуцсан захирал Б.Онон

Комиссын гишүүд:

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал С.Дөлгөөн

“ХаанЛекс Партнерс” ХХН-ийн Гүйцэтгэх захирал, Партнер И.Учралбаяр

“ХаанЛекс Партнерс” ХХН-ийн Ахлах хуульч О.Намуун

Комиссын нарийн бичиг:

ТУЗ-ийн Ажлын албаны хуулийн мэргэжилтэн Ж.Үүрцайх



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ

ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАРИУЦАХ
13:00-14:00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
14:00-14:05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комиссын дарга
14:05-14:10	Хурлын үйл ажиллагааг нээх	Хурлын дарга
14:10-14:15	Хурлын хөтөлбөр, дэгийг танилцуулах	Хурлын дарга
14:15-14:35	Танилцуулах асуудал: “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан тухай тайлан “ХААН Банк” ХК-ийн 2025 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлан	Гүйцэтгэх захирал
14:35-14:45	“ХААН Банк” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлт	“ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК
14:45-14:55	“ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн танилцуулга	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
14:55-15:00	“ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Хурлын дарга
15:00-15:10	“ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга	ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо
15:10-15:30	Асуулт, хариулт, саналын цаг	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
15:30-15:35	Хурлаар хэлэлцэн батлах асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлах	Тооллогын комиссын дарга
15:35-15:50	Санал хураалт: /Хэлэлцэн батлах асуудал тус бүрээр/ “ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв “ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох	Хурлын дарга
15:50-16:10	Завсарлага /санал тоолох/	Тооллогын комисс

16:10-16:15	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	Тооллогын комиссын дарга
16:15-16:20	Хурлын шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	Хурлын дарга

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг, санамж

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах, асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахад энэхүү дэгийг баримтална.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
3. Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулснаар Хурлын дарга албан ёсоор хурлыг нээнэ.
4. Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулна.
6. Хувьцаа эзэмшигч хурлыг аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг ашиглан бусдыг доромжлох, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
7. Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид эхний удаа Хурлын дарга урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан хувьцаа эзэмшигчийг Хурлын даргын зөвшөөрлөөр Хурал зохион байгуулах комисс хурлаас гаргах арга хэмжээг авна.
8. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг нэгтгэж, Тооллогын комиссын тогтоолыг тус комиссын дарга нь уншиж танилцуулна.
9. Хурлын дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаасныг мэдэгдэнэ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр

сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай**

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 29.2.7 дахь заалтад Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.9 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан Банкны 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр

сарын 24-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг
хэлэлцэж батлах тухай**

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 29.2.6 дахь заалтад Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал банкны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.9 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** Банкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 29.2.9 дэх заалтад Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалтад Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.13 дахь заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-ийн дагуу баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

ХААН БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

ТУЗ-ийн жилийн зардлын төсөв, сая төгрөгөөр
2026 оны төсөв¹

¹ ТУЗ-ийн төсөвт ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, нэмэгдэл болон ажил олгогч хуулийн этгээдийн нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлөлтийн зардал зэрэг багтана.

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон томилох тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 29.2.8 дахь заалтад Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал энэ хуулийн 32.3-т заасан Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.7 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.7 дахь заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурав (3) хүртэлх жилийн хугацаанд үргэлжилнэ. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар улируулан сонгож болохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэн, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэхээр бүх гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж, шийдвэрлэсэн болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

1. **ТОГТООХ НЬ:** Дараах нэр дэвшигчдийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр гурав (3) жилийн хугацаатайгаар томилсугай:
 - 1.1.
 - 1.2.
 - 1.3.
 - 1.4.
 - 1.5.
 - 1.6.
2. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон Банкны Дүрмийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
3. **ТОГТООХ НЬ:** Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах болон шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д олгосугай.
4. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгон томилох тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн 29.2.8 дахь заалтад Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал энэ хуулийн 32.3-т заасан Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байхаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.7 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.7 дахь заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурав (3) хүртэлх жилийн хугацаанд үргэлжилнэ. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар улируулан сонгож болохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж, тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэхээр бүх гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж, шийдвэрлэсэн болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

1. **ТОГТООХ НЬ:** Дараах нэр дэвшигчдийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр гурав (3) жилийн хугацаатайгаар томилсугай:
 - 1.1.
 - 1.2.
 - 1.3.
2. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон Банкны Дүрмийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
3. **ТОГТООХ НЬ:** Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Банкны нэрийн өмнөөс бүхий л баримт бичигт төлөөлөн гарын үсэг зурах болон шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д олгосугай.
4. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ
ХУУДАС №1**

Компанийн нэр: “ХААН Банк” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн иргэний бүртгэлийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт (УБ хотын цагаар) танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	“ХААН Банк” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах эсэх	☐	☐	☐
2.	“ХААН Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах эсэх	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн/Үнэт цаасны компани: _____ / _____

Саналын хуудсыг хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2026 оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. Та саналаа урьдчилсан байдлаар заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхагт хүргүүлэх, мөн цахим хэлбэрээр ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан өгөх боломжтой.
3. Хэрвээ өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, залруулгатай, тэмдэглэгээ буруу үйлдсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
5. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.
6. Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй.

Энэ хэсгийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____/ _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ
ХУУДАС №2**

Компанийн нэр: “ХААН Банк” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн иргэний бүртгэлийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт (УБ хотын цагаар) танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1.		
2.		
3.		
4.		
5.		
6.		
Хараат бус гишүүн		
1.		
2.		
3.		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн/Үнэт цаасны компани: _____ / _____

Саналын хуудсыг хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____/_____

2026 оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Ердийн гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, хараат бус гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
 - а. Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно. Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.
3. Та саналаа урьдчилсан байдлаар заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхагт хүргүүлэх, мөн цахим хэлбэрээр ХААН Банкны албан ёсны www.khanbank.com цахим хуудсаар дамжуулан өгөх боломжтой.
4. Хэрвээ өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцогдоно.
5. Засварласан, балласан, залруулгатай, тэмдэглэгээ буруу үйлдсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
6. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.
7. Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй.

Энэ хэсгийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____/ _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:
